



**БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ**

2017 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

Барилга, хот байгуулалтын салбарт жөндэрийн
талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Жөндэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан "Барилга, хот байгуулалтын салбарт жөндэрийн талаар баримтлах бодлого"-ыг хавсралтаар баталсугай.
2. Барилга, хот байгуулалтын салбарт жөндэрийн талаар баримтлах бодлогыг 2018-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт суулгаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.





БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯМ

Барилга, хот байгуулалтын сайдын
2017 оны 12 дугаар сарын-мын өдрийн
.....²⁰⁸ дугаар тушаалын хавсралт



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

(2018-2025)

Нэр томъёоны товч тайлбар

- Ажил ар гэрийн амьдралын тэнцвэр:** Эмэгтэй эрэгтэй ажиллагчдын гэр бүлийн үүрэг хариуцлагыг анхаарч тооцоогүй бодлого төлөвлөлт нь эмэгтэйчүүдийг ажлын байрандаа ахиж дэвшихэд садаа болж, цалин хөлс багатай, баталгаагүй ажил руу түлхдэг ба харин эрэгтэйчүүдийг гэр бүлийнхээ амьдралд оролцох боломж, чадварыг нь хязгаарлан эрүүл мэндийн эрсдлийг нь ихэсгэдэг. Тиймээс хөдөлмөр эрхлэлт болон гэр бүлийн үүрэг хариуцлагыг зохистойгоор хослуулж ажил ар гэрийн тэнцвэрийг хангах нь жендерийн тэгш байдлыг хангах үйл явцын нэгэн хэсэг болж байна.
- Жендерийн дүн шинжилгээ:** Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд сууриссан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм. Үүнд зөвхөн хүйсээр ангилсан мэдээлэл бус, бодлогын дүн шинжилгээ, чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигладаг.
- Жендерийн мэдрэмж:** Эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадварыг тодорхойлсон ойлголт.
- Жендерийн статистик:** Хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулах, нэгтгэх, шинжлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах замаар жендерийн тулгамдсан асуудлыг илүү тодорхой ойлгох, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тооцох арга хэрэгсэл.
- Жендерийн эрх тэгш байдал:** Эмэгтэй эрэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ.
- Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх (*Gender mainstreaming*):** Бүх хүрээ, түвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги.
- Жендерийн хэвшмэл ойлголт:** Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, тодорхой бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурин талаарх хялбаршуулсан ерөнхий ойлголт бөгөөд тэдний ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлтөд анхаарч тусгахад садаа болж, шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг.
- Жендерийн шалгуур үзүүлэлт:** Жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тоон болон чанарын үзүүлэлтүүд. Ийм үзүүлэлтүүд нь мөн жендерийн тэгш байдлын агуулга, мөн чанарын талаар мэдээлэл өгдөг.
- Хүйсээр ангилсан мэдээлэл:** Статистикийн нэгэн үзүүлэлт болох хүйсээр ангилсан тоо мэдээлэл нь охид хөвгүүдийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн бодит нөхцөл байдлыг харьцуулан үзэх, жендерийн зөрүү, тэгш бус байдлыг илрүүлэн залруулах боломж олгохоос гадна бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж болон салбарын үйл ажиллагаан дахь эмэгтэй эрэгтэйчүүдийн оролцооны дүр зургийг хараад тусалдаг.

Өмнөх үг

Хөгжил дэвшилд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд оролцох болон үр ашгийг нь тэгш хүртэх бодит боломжийг эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд буй болгоход жендерийн тэгш байдлын жинхэнэ утга учир оршдог билээ. Жендерийн тэгш байдлыг хүйсийн харьцаа төдийхнөөр, эсвэл эмэгтэйчүүдийн асуудал мэтээр ойлгож ирсэн байдал нэгэнт улирч, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн харилцан адилгүй үүргээс үүдэлтэй ялгаатай хэрэгцээг анхаарч тооцох, нийгмийн янз бүрийн бүлгийн эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд хөгжлийн үйл явцад оролцох, мөн түүний үр шимээс хүртэхэд ямар саад бэрхшээл тулгарч байгааг судлан шинжилж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд хүрээнд анхаарч, шийдвэрлэх цогц хандлага нэвтрөрч байна. Энэ нь өнөөдөр Тогтвортой хөгжлийн зорилго 2030-ийн “хөгжлийн явцад хэнийг ч үл орхигдуулах” зарчмыг хэрэгжүүлэх арга зам болж байна.

Жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ нь улс орны, салбарын өмнө тавигдаж буй зорилт, төлөвлөсөн үйл ажиллагааг илүү оновчтой, үр өгөөжтэй бөгөөд хүртээмжтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Жендерийн бодлогын хүрээнд хийх судалгаа шинжилгээ, бүрдүүлэх мэдээллийн сан нь салбарын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд хувь нэмэр оруулдаг. Эмэгтэй эрэгтэйчүүдийн ялгаатай бодит хэрэгцээг анхаарч тооцсон удирдлагын арга барил, байгууллагын соёлыг төлөвшүүлэх цогц арга хэмжээ нь эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, улмаар нийгэм дэх ялгаатай хэрэглэгчдийн хэрэгцээнд бүтээгдэхүүн үйлчилгээг нийцүүлэхэд тусалдаг. Жендерийн оновчтой бодлого төлөвлөлт нь мөн салбар, байгууллагын нийгэм дэх дүр төрхийг өргөж, түншлэгч, хэрэглэгчдийн хандлага, үнэлгээг дээшлүүлэх, салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагааг сайжруулахад нөлөөлдөг.

Барилга хот байгуулалтын салбар нь жендерийн бодлогоо салбарынхаа хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг манай улсын аж үйлдвэрийн салбарууд дундаас анхлан хийж, үлгэр жишээ болж байна. Барилга, хот байгуулалтын салбарын үйл ажиллагаа нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ганц бие эцэг эхчүүд, өндөр настан, залуу гэр бүлүүд, охид хөвгүүдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх нөхцлийг бүрдүүлэхээс гадна нийгэм дэх ялгavarлал, шударга бус байдлыг арилгахад гүйцэтгэх үүргээрээ жендерийн хувьд нэн чухал утга агуулгатай.

Энэхүү жендерийн бодлого нь эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд амьдарч хөдөлмөрлөх эрүүл, аюулгүй бөгөөд ялгаатай хэрэгцээг нь харгалзсан таатай орчин бий болгох, барилга, хот төлөвлөлтийн үйл явцад оролцох боломжийг бүрдүүлэх хүрээнд тулгамдсан асуудлыг шийдэх гарц, арга замыг олох, хэрэгжүүлэхэд чиглэснээрээ нийгэм дэх жендерийн тэгш байдалд чухал хувь нэмэр оруулах төдийгүй дэлхийн хөгжингүй улс орнуудын барилга, хот төлөвлөлтөд баримталж буй байгаль орчин, нийгэм, эдийн засгийн цогц хандлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг болно хэмээн найдаж байна.

Жендерийн зөвлөх баг

Нэг. Нийтлэг үндэслэл

Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлого нь (цаашид “Салбарын жендерийн бодлого” гэнэ) салбарын хөгжлийн бодлогын үйл явцад жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээг тогтоосон дунд хугацааны хөгжлийн төлөвлөлт төдийгүй жендерийн талаар тус салбарт баримтлах урт хугацааны бодлогын чиглэлийг тодорхойлох үндэсийг тавьж буй суурь баримт бичиг юм.

Энэхүү салбарын жендерийн бодлого нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021) болон Барилга, хот байгуулалтын салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаатай уялдан хэрэгжинэ.

Салбарын жендерийн бодлогыг барилга, хот байгуулалтын салбарын ажилтан, албан хаагчдын жендерийн практик ба стратеги хэрэгцээг тодорхойлох зорилгоор 2017 оны 7-10-р сард хийгдсэн “Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ”, салбарын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан боловсруулав.

Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээгээр барилга хот байгуулалтын салбарын төр ба хувийн хэвшлийн байгууллагуудын тухайд эмэгтэй эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг анхаарч, эрүүл мэнд, аюулгүй байдал, ажил-ар гэрийн тэнцвэрийг хангасан, тогтвортой орлогын эх үүсвэр болгох ажлын орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа нь илэрсэн. Тус салбарт хувийн хэвшлийн оролцоо давамгайллах болсон өнөөгийн нөхцөлд эмэгтэй эрэгтэй ажиллагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, ажил-ар гэрийн тэнцвэрийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг илрүүлэн бодлого төлөвлөлтөд тусгахын тулд үйл ажиллагааны үр дүн амжилттыг бүтээн байгуулалт, төлөвлөгөөний биелэлт, бүтээгдэхүүний гарцаар үнэлж, харин хүний нөөц үйлдвэрлэлийн нэгэн төрлийн “орц” болж ирсэн уламжлалт хандлагыг өөрчлөх шаардлага тулгарч байна.

Ялангуяа улирлын буюу түр ажил эрхлэлт барилгын салбарт түгээмэл, ийм хэлбэрийн ажил эрхлэгчид тогтвортой цалин хөлсгүй, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдахгүй, ар гэрийн амьдралаа төлөвлөх боломж хомс байна. Тэдний мэдээлэл авах, сургалтад хамрагдаж мэргэжсэн ур чадвар эзэмших, шинэ технологи, банк санхүүгийн үйлчилгээний ашиг тусыг хүртэх боломж хязгаарлагдмал, хөдөлмөрийн харилцааны хүрээнд эрх зүйн тусламж үйлчилгээний гадна үлдэж байна. Хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор ядуу эмэгтэйчүүд зохистой хөдөлмөр хамгийн дутагдалтай байдаг албан бус эдийн засагт орж ажилладаг¹ бөгөөд ийм ажил эрхэлж буй хүмүүс осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчинд өртөх нь дэлхий даяар илүү байна. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 10 орчим жилээр богино, өвчлөл, осол гэмтлийн хувь өндөр, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсээр байгаа манай орны хувьд энэ нь эн тэргүүнд анхаарах асуудал болж байна.

Барилга, хот байгуулалтын салбарыг эрэгтэйчүүд давамгайлсан, эмэгтэйчүүд ажиллахад тохиромжгүй гэж үзэх жендерийн хэвшмэл ойлголт ялангуяа удирдах ажилтнуудын дунд түгээмэл байгаа нь эмэгтэй, эрэгтэй

¹ Олон улсын Хөдөлмерийн бага хурлын 2002 оны 90 дүгээр чуулганаас батлагдсан зохистой хөдөлмөр ба албан бус секторын тухай Тогтоол

ажиллагчдын хэн хэнд нь таагүй нөлөөтэй байна. Энэ хэвшмэл ойлголт нь тухайлбал барилга, хот байгуулалтын салбарт ажилладаг эрэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн амьдрал, үр хүүхдийн хүмүүжилд, мөн өөрсдийн эрүүл мэндэд зарцуулах цаг хомс байдлыг байгууллагын соёлын хүрээнд баримтлагдах хэв ёс болгож, тэдний эрүүл мэндийн зан үйлийн онцлогоос үүдэх эрсдэлийг анхаарлын гадна орхигдуулж байна.

БХБ салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй хийх, хэрэгжүүлэхэд өнөөгийн статистик мэдээллийн байдал хангалтгүй байна. Барилга, хот байгуулалтын яам, түүний харьяа төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд эрэгтэйчүүд 55.7, эмэгтэйчүүд 44.3 хувийг эзэлж байгаа бол удирдах албан тушаалтны дунд эрэгтэйчүүд 84.8 хувь, эмэгтэйчүүд 15.2 хувийг эзэлж байна. Хувийн хэвшилд ажиллагчдын хүйсээр ангилсан мэдээллийг тогтмол, бүрэн цуглуулж ашиглахгүй байгаагаас тухайн салбарт ажиллагчдын 40 орчим хувийг эзэлж буй эмэгтэйчүүдийн оролцоо, тэдэнд тулгарч буй асуудал “орхигдож” байгаагаас гадна нийт ажиллагчдын ажлын орчин нөхцлийг бодитой үнэлэх боломжгүй байна.

Хүйсээр ангилсан мэдээллийг ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн тоо төдий байдлаар бус, цалин хөлс, эрүүл мэнд, нийгмийн даатгалд, мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдалт, шагнал урамшуулал, ажлын цагийн ачаалал, илүү цагаар ажилласан байдал зэрэг олон үзүүлэлтээр цуглуулж, нэгтгэх шаардлагатай байна. Хүйсээр ангилсан мэдээллийг мөн тухайн салбарт ажиллаж буй гадаадын ажиллах хүчний тухайд ч гаргах шаардлагатай. Барилга, хот байгуулалтын чиглэлээр суралцаж буй эмэгтэй эрэгтэй оюутнуудын хүйсийн харьцаа нийт дүнгээрээ тэнцвэртэй (40 хувь нь эмэгтэйчүүд) байгаа ч цаашид мэргэжил тус бүрээр нарийвчилсан дүр зургийг гаргаж, салбарын ажлын байрны эрэлт хэрэгцээтэй илүүтэй нийцүүлэх шаардлагатай. Мөн газрын харилцаатай холбоотой хүйсээр ангилсан мэдээллийг бүх түвшинд тогтмол нэгтэн ашиглах нь газрын зүй зохистой хамгаалалт, ашиглалтыг бий болгоход эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн идэвхитэй оролцоог дэмжих ажлын үндэс суурь болно.

Нийтийн аж ахуйн салбарт ялангуяа орон нутагт инженер техникич дутагдалтай, орон нутгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд барилгын чиглэлээр охидыг сургаж байгаа ч тэд мэргэжлээрээ ажиллахгүй, мөн барилгын компаниудад мэргэжлийн чадварлаг ажилчин хүрэлцээгүй зэрэг хүний нөөцийн эрэлт нийлүүлэлтийн зөрүүг анхаарахаас гадна сургалтын тогтолцоо, чанар, үр дүнг сайжруулах замаар суралцагч охид хөвгүүдийн цаашдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэрэгтэй байна.

Барилга, хот байгуулалтын салбар дахь зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гол арга зам нь салбарын төр, хувийн хэвшлийн байгууллагын эмэгтэй эрэгтэй нийт ажиллагчдын ялгаатай хэрэгцээнд анхаарсан, ажил-ар гэрийн тэнцвэрийг хангасан хүн төвт, нийгмийн хариуцлагат удирдлагын зарчмыг нэвтрүүлэх явдал байна. Барилга, хот байгуулалтын салбарын бодлого төлөвлөлтийг хүн төвтэй, жендэрийн мэдрэмжтэй болгохын тулд эн тэргүүнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг “ил” болгох буюу хүйсээр ангилсан тоон мэдээлэл, үзүүлэлтүүдийг тогтмол, бүрэн цуглуулах, нэгтгэх, түгээж ашиглах, жендэрийн мэдрэмжтэй судалгаа шинжилгээг хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн байгууллагуудад байгаа сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ тулгарч байна.

Барилга, хот байгуулалт дахь жендэрийн асуудал нь салбарын хүний нөөц, ажиллагчдын хамрахаас гадна, тус салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний үр нөлөө жендэрийн мэдрэмжтэй байх асуудлыг авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Барилга, хот байгуулалт нь улс үндэстний соёлжилт, иргэншлийн хэмжүүр болж, үнэт зүйл, үнэлэмж, амьдралын хэв маягт нөлөөлж байдаг тул жендэрийн үр дагавар нь өргөн хүрээтэй. Барилга, хот байгуулалтын салбарын эрх зүй, бодлогын орчинд аль нэг нийгмийн бүлгийг шууд ба шууд бусаар ялгаварласан агуулга огт байхгүй боловч энэ нь бүтээгдэхүүн үйлчилгээг бүх насны эмэгтэй эрэгтэйчүүдийн, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэх баталгаа болж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг салбарын эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд тусгасан жишгийг туршлага болгон ялгаатай хэрэглэгчдийн хэрэгцээг салбарын бодлого төлөвлөлтөд анхаарч тусгах, бүх түвшинд хэрэгжүүлэх, оршин суугчдын оролцоотой хяналтыг хөгжүүлэх замаар бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, үр өгөөжийг сайжруулах асуудал өнөөдөр тулгамдаж байна.

Амьдралын түвшний ялгаа улам ихэсч, олон соёлын нөлөө хүчтэй болж буй өнөө үед нэг хороолол, орон сууцанд орлогын янз бүрийн түвшний хүмүүс холилдон амьдрах нөхцлийг бүрдүүлэх замаар үл тэвчих, ялгаварлан гадуурхах хандлагыг бууруулж, гэмт хэрэг, хүчирхийллээс сэргийлэх, аймгийн төв, сум болон багийн төв, тосгодыг амьдралын таатай орчин болгож, нийслэлээс гадагш айл өрхийн амьдралын өртөг зардал буурч байхад чиглэсэн үйлчилгээний өртгийн зохицуулалт хийх замаар шилжих хөдөлгөөнийг сааруулах зэрэг жендэрийн үр нөлөө бүхий олон асуудал барилга, хот байгуулалтын салбарын бодлогын хүрээнд шийдлээ хүлээж байна.

Мөн орлого багатай залуу гэр бүлүүдийн хүүхдээ төрүүлж, өсгөн хүмүүжүүлэхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжсэн, гэр бүлүүдийн өөрчлөгдөн буй бүтэц, гэр бүлийн үнэт зүйл, харилцааны асуудлыг анхаарч тусгасан, оршин суугчдад амьдралын үе шат бүртээ тохирсон сонголт хийх боломж бүрдүүлсэн, ялгаатай хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн, орон нутгийн онцлогийг тусгасан, эмэгтэй эрэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх тэгш боломж бүрдүүлсэн хот төлөвлөлт, барилгын архитектур дизайныг хөгжүүлэх замаар жендэрийн мэдрэмжтэй нийгмийн хөгжлийн бодлого, үйл ажиллагааг дэмжих боломж барилга, хот байгуулалтын салбарт нээлттэй байна.

Нийслэл хот өсөн тэлж байгаа энэ цаг үед хотод амьдрах, биеэ авч явах соёл, барилга байгууламжийн ашиглалтын талаарх мэдээллийг телевиз, интернэтээр оршин суугчдын жендэрийн ялгаатай үүрэг, хэрэгцээтэй уялдуулан системтэй хүргэх, үүнд сууц өмчлөгчдийн холбоод болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Эдгээр асуудлыг шийдэхийн тулд салбарын жендэрийн асуудлыг бүх түвшинд уялдуулан зохицуулах чадамж бүхий тогтвортой ажиллах бүтэц, тогтолцоог бүрдүүлж, хүний нөөц бэлтгэх, салбарын бодлого төлөвлөлтийн хүрээнд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг ойлгоцыг нэмэгдүүлэх, ялангуяа салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний жендэрийн үр нөлөөг анхаарч тооцох талаарх ойлголт хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай байгаа нь оролцонд суурилсан жендэрийн үнэлгээгээр илэрсэн юм. Салбарын хүний нөөцийг жендэрийн мэдрэмжтэй бодлогоор хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох бодит нөхцөл бололцоо бүрдүүлэхийн тулд юуны өмнө салбарын удирдах ажилтан, бодлого төлөвлөлт, хяналт үнэлгээ, хүний нөөц, төсөв санхүүгийн асуудал

хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдыг ажлын байрны чиг үүргийн дагуу жендэрийн үе шаттай сургалтаар чадавхижуулах хэрэгцээтэй байна. Барилга хот байгуулалт, газрын харилцааны салбарын ажилтан, албан хаагчдыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд жендэрийн асуудлыг зохистой байдлаар нэгтгэх, холбогдох ажилтнуудыг жендэрийн судалгаа шинжилгээний арга зүйд сургах хэрэгцээтэй байна.

Барилга хот байгуулалт, газрын харилцааны салбарын үйл ажиллагаанд эмэгтэй эрэгтэйчүүдийн, хүн амын бүлгүүдийн оролцох чадавхийг дээшлүүлэхийн зэрэгцээ салбарын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын нэгдмэл үйл ажиллагааг дэмжих суурь үзүүлэлтүүдийн багцыг өнөөгийн норм нормативын хүрээнд гарган түгээн дэлгэрүүлэх нь тэдгээрийг цаашид боловсронгуй, жендерийн мэдрэмжтэй болгох чухал алхам болно. Энэхүү жендерийн бодлогын хүрээнд барилга, хот байгуулалт, газрын харилцааны үйл явц, ашиглалт, үйлчилгээ, тэдгээрт тавих хяналтад нийгмийн тэгш оролцооны боломжуудыг тодорхойлох, бүтээн байгуулалтын төлөвлөлтийн шатанд ялгаатай хэрэглэгчид, тэдгээрийн ялгаатай хэрэгцээг судлан тооцох эрх зүй, бодлогын орчныг бүрдүүлэх, шилдэг туршлага, ололт амжилтыг тодруулан түгээн дэлгэрүүлэх ажлыг өргөн хүрээний түншлэл хамтын ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх болно.

Зураг 1. Барилга, хот байгуулалтын салбарын жөндэрийн мэдрэмжтэй бодлогын цикл



Энэхүү бодлого нь барилга, хот байгуулалтын салбарын олон талт түншлэгчдийн жөндэрийн асуудалд зарцуулж буй хүний болон санхүүгийн нөөцийг илүү үр бүтээлтэй хуваарилан зарцуулах боломж бүрдүүлэх ба эцсийн дүндээ салбарын хүний нөөц болон бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжлийн шинэ шатанд гаргаж, жөндэрийн тэгш байдлыг хангахад жинтэй хувь нэмэр оруулахад чиглэгдэнэ.

Хоёр. Бодлогын зорилго

Барилга, хот байгуулалтын салбарын хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээгээр дэмжинэ.

Гурав. Бодлогын зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааны чиглэл

Салбарын жендэрийн бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хот суурин, барилга байгууламжийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, бүтээн байгуулах үндэсний чадавхийг сайжруулах;

Хүрэх үр дүн: Барилга, хот байгуулалтын салбарын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийх мэдлэг чадавхи бүрдэж, тогтолцоо хөгжинө.

2. Барилга, хот байгуулалтын салбарт ажиллагчдын зохистой хөдөлмөр эрхлэлтийг жендэрийн мэдрэмжтэй хүний нөөцийн бодлогоор дэмжих;

Хүрэх үр дүн: Салбарын ажиллагчдад жендэрт нийцтэй ажлын орчин нөхцлийг бүрдүүлэх цогц үйл ажиллагаа өrnөж, эмэгтэй эрэгтэй нийт ажиллагсдын ажлын орчин нөхцөл сайжирна.

3. Барилга хот байгуулалтын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний жендэрийн мэдрэмжийг сайжруулахад хэрэглэгчид, түншлэгчдийн оролцоог дээшлүүлэх.

Хүрэх үр дүн: БХБ салбарын жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг дэмжих, хөгжүүлэх түншлэл, хамтын ажиллагаа өргөжин, эмэгтэй эрэгтэй оршин суугчдын оролцоо сайжирна.

Зорилт 1-ийн хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 1.1.БХБ-ын салбарын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэгтгэх мэдлэг ойлгоц, чадавхийг бүх түвшинд бүрдүүлэх,
- 1.2.БХБ-ын салбарын хэмжээнд жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлэх,
- 1.3.БХБ-ын салбарын эрх зүй, бодлогын орчныг жендэрийн мэдрэмжтэй судалгаа, шинжилгээнд тулгуурлан хөгжүүлэх,
- 1.4.БХБ-ын салбарын хяналт үнэлгээний тогтолцоонд ажиллагчид, хэрэглэгчид, бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх.

Зорилт 2-ын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 2.1.Зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн талаар нэгдсэн ойлголт зөвшүүлэлтийг бий болгож хамтын ажиллагааг эхлүүлэх
- 2.2.Салбарын хүний нөөцийн нас, хүйсээр ангилсан мэдээллийн санг хөгжүүлж, ашиглалтыг сайжруулах

- 2.3. Ялгаварлан гадуурхлаас сэргийлэх, жендэрийн асуудлаар санал гомдол хүлээн авч шийдвэрлэх механизмыг байгууллагын түвшинд хөгжүүлэх
- 2.4. Салбарын төр, хувийн хэвслийн байгууллагуудад жендэрийн тэгш байдалд ээлтэй “хүн төвт, нийгмийн хариуцлагат” удирдлагын загварыг түгээн дэлгэрүүлэх
- 2.5. Техник технологийн дэвшилийг нэвтрүүлж, ажлын орчин нөхцлийг сайжруулах замаар эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломжтой ажлын байрны тоог нэмэгдүүлэх

Зорилт 3-ын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 3.1. Хот суурин газрын оршин суугчдын эрүүл, аюулгүй амьдралын орчны жендэрийн мэдрэмжтэй багц үзүүлэлт - Амьдралын чанарын суурь стандарт (АЧСС) гарган салбарын оролцогч талуудын үйл ажиллагаанд мөрдлөг болгож, түгээн сурталчлах, сайжруулах
- 3.2. Хот суурин, барилга байгууламжийн төлөвлөлт, бүтээн байгуулалтад эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн оролцох чадавхи, боломжийг сайжруулах
- 3.3. БХБ салбарын жендэрийн мэдрэмжтэй бодлогын цаашдын хөгжлийг түншлэл, хамтын ажиллагаагаар дэмжих

Дөрөв. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа

Бодлогыг 2018-2025 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Эхний үе шат буюу 2018-2021: Энэ үе шат нь Засгийн газраас 2017-2021 онд хэрэгжүүлэх “Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны хэрэгжилттэй уялдана.

Хоёрдахь үе шат буюу 2022-2025: Энэ үе шат нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ийн хэрэгжилттэй уялдана.

Тав. Бодлогыг хэрэгжүүлэх төсөв, хөрөнгийн эх үүсвэр

Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- Хандивлагч улс, олон улсын байгууллагын тусlamжийн хөрөнгө;
- Хувийн хэвслийн хандив, тусlamжийн хөрөнгө;
- Бусад.

Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр нарийвчлан гаргаж, голлон хэрэгжүүлэгч болон оролцогч талуудыг тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Барилга хот байгуулалт, газрын харилцааны салбарт хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлдэг хамтын гэрээ байгуулсан олон улсын болон бусад байгууллагуудын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, дэмжлэгийнхээ хоёроос доошгүй хувийг тус бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлнэ.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Бодлогын хэрэгжилтийг Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахь Жендерийн Үндэсний Хорооны салбар зөвлөл удирдан зохион байгуулна.

Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хяналт-шинжилгээний үр дүнг Жендерийн салбар зөвлөл хэлэлцэн, салбарын холбогдох бодлого төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагаанд тусгана. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу бодлогын хэрэгжилтийг Жендерийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 2-р сарын 20-нд багтаан тайлagnана.

Бодлогын эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг 2022 оны эхний улиралд багтаан үнэлж, хоёрдугаар шатанд авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

—o0o—

Барилга, хот байгуулалтын салбарт жөндэрийн талаар баримтлах бодлогыг (2018-2025) хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө, Уе шатааор

<p>зохицтой хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жэндэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн асуудлаар гарын авлага боловсруулан турших.</p> <p>7. Архитектор, зураг төсөл, хот төлөвлөлтийн нийт мэргэжилтнуудад жэндэрийн мэдрэмжтэй барилга, хот байгуулалтын чиглэлээр сургалт, Нөлөөллийн ажил хийх.</p> <p>8. Салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн ажилтнуудад зориулсан салбарын жэндэрийн бодлоготой уялдсан жэндэрийн Уйл ажиллагааны төлөвлөлт хийх, шалтуур ашиглах гарган удирдамж боловсруулан хүргүүлэх.</p>	<p>байгуулалтын талаарх агуултыг тусгах.</p> <p>4. БХБ салбарын Уйл ажиллагаанд төрийн хяналт Унэлгээг хэрэгкүүлэгчдэд жэндэргээг хөдөлмөрийн орчин бурдуулэхэд зөвлөгөөгөөгөө чиглэлээр сургалт хийх.</p> <p>5. Салбарын хүний нөөц бэлтгэж буй төр, хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөр дэх заавал үзэх хичээлийн агуулгад нийгэм, жэндэрийн Унэлгээ, шинжилгээ, жэндэрийн мэдрэмжтэй барилга, хот байгуулалтын талаар тусгах.</p>	<p>МХЕГ², байцаагчдын тоо • Нийгэм, жэндэрийн асуудлыг тусгасан хөтөлбөрийн эзлэх хувь, боловсролын түвшнээр</p>
<p>2.БХБ-ын салбарын хэмжээнд жэндэрийн тэгш байдлыг хангах тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлэх</p>	<p>1. Салбарын жэндэрийн бодлоготой уялдуулан салбар жэндэрийн зөвлөлийг ажиллаж шинэчлэн батлах.</p> <p>2. Нийслэлийн төлөвлөлт, төлөвлөгөөний тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлэх</p>	<p>хот 1. Барилга, байгуулалтын салбарын Уйл ажиллагааны нийгэм, жэндэрийн Ур нөлөө болон нийзэмд гарч буй өөрчлөлтийг тогтолцоог тусгасан ажилтны тоо, хүйсээр, байгууллагаар</p> <p>хот • Жэндэрийн судалгааг ажлын төлөвлөгөөндөө тусгасан байгууллагын тоо • Жэндэрийн чиглэлээр үйл ажиллагааны зардал төсөвлөсөн</p>

² Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
³ Уйлдвэрчний эвлэл

<p>(өрөнхий архитекторын ажлын жандэрийн хариуцсан мэргэжилтэн томилон ажиллуулах.</p> <p>3.Аймаг, дуургийн ГХБХБГ⁴-уудад салбарын жандэрийн болгыг хэрэгжүүлж, тайлатах удирдамж хургуулэх.</p> <p>4.Салбарын ажиллагааны чиглэлүүдийн жандэрийн тодорхойлон байртай холбон жандэрийн байдлыг хангах хариуцлагыг хуваарилах.</p> <p>5.БХБ-ын салбар жандэрийн байдлыг хангахад ТББ, мэргэжлийн гүйцэтгэх тодорхойлж, жандэрийн ажиллах дээшлүүлэх байгуулах.</p>	<ul style="list-style-type: none"> Жендерийн хэрэгжүүлж, удирдамж ашигласан ГХБХБГ-ын эзлэх хувь, Сургалтад хамрагдсан ТББ⁵, Мэргэжлийн холбоодын ажилтнуудын тоо, хүйсээр Ундсан чиглэлүүдийн агуултыг зэрэглэж ажлын байртай холбон жандэрийн тэш байдлыг хангах уурэг хариуцлагыг хуваарилах. Дахь тэш байдлыг хангахад ТББ, Мэргэжлийн холбоодын гүйцэтгэх тодорхойлж, жандэрийн ажиллаар чадавхийг сургалтууд байгуулах. 	<p>бодлогыг тайлатах судалгааны тогтолцоог бий болгон чадавхижуулах.</p> <p>2.Салбарын жандэрийн бодлогын хэрэгжилтэд оролцоонд сууринсан жендерийн (ОСЖУ) Унэлгээ хийж, салбарын талаар баримтлах бодлогын цаашдын чиглэлийг тодорхойлох.</p> <p>3.Оролцоонд сууринсан жендерийн Унэлгээний дунгийн хэлэлцүүлийг зохион байгуулах.</p> <p>4.Салбарын жандэрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд ТББ, мэргэжлийн оролцо, чадавхи бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлох хэлэлцүүлэг зохион байгуулах.</p>	<ul style="list-style-type: none"> ОСЖУ-ний тайлан ОСЖУ-ний хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр Хэлэлцүүлэгт оролцсон Мэргэжлийн холбоодын тоо
<p>3.БХБ-ын салбарын эрх зүй, бодлогын орчныг</p>	<p>1.Салбарын бутээгдэхүүн, Улжилгээний жендерийн салбарын Үр нөлөө, Улп</p>	<ul style="list-style-type: none"> Жендерийн судалгааны тайланийн хэлэлцүүлэг 	<p>1.Амьдралын чанарын стандарт (АЧСС), хэрэгжилтийг шүүий эмээтэй</p> <p>• АЧСС-ын тулгуурлан шинэчилсэн норм,</p>

⁴ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
⁵ Төрийн бус байгууллага

<p>6. Хэрэглэгчдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн дизайн (<i>Universal design feature</i>), төлөвлөлтийг нэвтрүүлэх арга замыг хэлэпчэн тодорхойжж зөвлөмж гарган хэрэгжүүлэх.</p> <p>7. Хот, суурин руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, түүнийг дагалдан гарах нийтийн олон талт сөрөг ур нөлөөтг сааруулах, бус нутгийн хөгжлийг хангахын тулд амьдралын ёрттийг төвөөс гадагш буурах зарчмаар тогтоох боломжийг судлан бодлогод туслах.</p>	<p>ялгаатай хэрэгцээг тооцож, байгаль орчин, нийтэм, жэндэрийн үр нөхөөг үнэлэх аргачалыг боловсруулан нэвтрүүлэх.</p> <p>6.Барилга, хот байгуулалтын чиглэлээр суралцагчдын хүйсийн харьцааг мэргэжил тус бүрээр тогтмол нарийвчлан гаргаж, хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт нийлүүлэлтэд гарч буй зерүү болон түүний жэндэрийн шинж чанарыг нарийвчлан судлаж салбарын хүний нөөц бэлтгэх бодлого төлөвлөлтэд ашиглах.</p>	<p>хэрэгцээг судлан байгаль, жэндэрийн үр үнэлэх аргачалыг боловсруулан нэвтрүүлэх.</p> <p>6.Барилга, хот байгуулалтын чиглэлээр суралцагчдын хүйсийн харьцааг мэргэжил тус бүрээр тогтмол нарийвчлан гаргаж, хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт нийлүүлэлтэд гарч буй зерүү болон түүний жэндэрийн шинж чанарыг нарийвчлан судлаж салбарын хүний нөөц бэлтгэх бодлого төлөвлөлтэд ашиглах.</p> <p>1.Салбарын төрийн байгууллагуудын хийж буй судалгаа, үнэлгээнд удирдамж хэрэглэгчид, ажиллагчдаас судалгаанд нас, хүйсийн үзүүлэлтийг оруулах, үр дунг тайлагнаадаа нас, хүйсээр шинжлэх удирдамж, мөрдүүлэх.</p> <p>2.Газрын нэгдмэл сангийн үзүүлэлтуүдийг нэвтрүүлэх улсын нэтдсэн тайланд</p>
<p>4.БХБ-ын салбарын хяналт үнэлгээний тогтолцоонд ажиллагчид, хэрэглэгчид, бүтээгдэхүүн үйлчилгээтийг холбоотой жэндэрийн шалгур үзүүлэлтуүдийг нэвтрүүлэх</p>	<p>• Нас, Узүүлэлтийг судалгаа, хэрэглэх үнэлгээнд удирдамж хэрэглэгчид, ажиллагчдаас авах судалгаанд нас, хүйсийн үзүүлэлтийг оруулах, үр дунг тайлагнаадаа нас, хүйсээр шинжлэх удирдамж, мөрдүүлэх.</p> <p>2.Газрын нэгдмэл сангийн үзүүлэлтуүдийг нэвтрүүлэх улсын нэтдсэн тайланд</p>	<p>1.Хэрэглэгчдээс авах хүйсийн судалгааны асуултыг бүтээгдэхүүн, үйлчилгээний жэндэрийн мэдрэмжтэй үнэлэхүйц байдлаар шинэчлэх.</p> <p>2.БХБ-ын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг хэрэглэгчидтэй холбоотой жэндэрийн тоон болон чанарын багц шалгур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> Хэрэглэгчдийн судалгааны тайлан дахь бүтээгдэхүүн, үйлчилгээний жэндэрийн мэдрэмжтэй холбоотой агуулга БХБ-ын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглэгчидтэй холбоотой жэндэрийн багц шалгур үзүүлэлтуүдийг

	<p>газар эзэмшигч, ашиглагчдын талаарх бүх мэдээллийг нас, хүйсээр ангилан гарахад шаардагдах мэдээллийн хэрэгцээг сум, дүүрэг, аймаг, нийспэлийн түвшинд унэлж, шаардагдах зохицуулалтыг хийх.</p> <p>3.БХБ-ын ажиллагчдын орчин жендэрийн нэхцлийн мэдээллийн төлөвлөгөөд хамрагдаж иргэдийн хүйсээр дэлгэрэнгүй мэдээллийн сан ажлын хөхцлийн жендэрийн нэхцлийн мэдээлжийг унэлэх чанарын багц узыулэлтуудийг салбарын ажиллагааны чиглэл тус бурийн харгалзан гаргаж тэр, хувийн байгуулагуудад турших.</p> <p>4.Гэр төлөвлөйт, шилжүүлэх ажиллагаанд хамрагдаж бүй иргэдийн талаарх мэдээллийг нас, хүйс, орлого, бэрхшээл узыулэлтээр бүрдүүлэх.</p> <p>5.БХБЯ, тиүүний терийн ажилтнуудын ажлын ачааллын талаарх агуулга узыулэлтуудийг салбарын ажиллагааны чиглэл тус бурийн харгалзан гаргаж тэр, хувийн байгуулагуудад турших.</p>	<ul style="list-style-type: none"> Багц турисан байгууллагын тоо, тэр, хэвшлээр • Гэр хорооллын дахин төлөвлөгөөд хамрагдаж иргэдийн хүйсээр дэлгэрэнгүй мэдээллийн ажлын хөхцлийн жендэрийн нэхцлийн мэдээлжийг унэлж чанарын багц узыулэлтуудийг хувийн хэвшлийн байгуулагуудад унэгээний тайлан дахь ажлын хөхцлийн жендэрийн нэхцлийн мэдээлжийг унэлэх чанарын багц шалтуур узыулэлтуудийг салбарын ажиллагааны чиглэл тус бурийн харгалзан гаргаж тэр, хувийн байгуулагуудад турших. Багц турисан байгууллагын тоо, тэр, хэвшлээр • Гэр хорооллын дахин төлөвлөгөөд хамрагдаж иргэдийн хүйсээр дэлгэрэнгүй мэдээллийн ажлын хөхцлийн жендэрийн нэхцлийн мэдээлжийг унэлж чанарын багц узыулэлтуудийг хувийн хэвшлийн байгуулагуудад унэгээний тайлан дахь ажлын хөхцлийн жендэрийн нэхцлийн мэдээлжийг унэлэх чанарын багц шалтуур узыулэлтуудийг салбарын ажиллагааны чиглэл тус бурийн харгалзан гаргаж тэр, хувийн байгуулагуудад турших. 	<p>Узуулэлтуудийг бүх түвшинд нэвтрүүлэх. 3.БХБ-ын салбарын ажиллагчдын орчин нэхцлийн жендэрийн мэдээлжийг шалтуур узыулэлтууд ашилган унэлсэнүнэлүүлсэн байгууллагын тоо, үйл ажиллагааны чиглэл, тер, хувийн хэвшлээр байгууллага шалгаруулах үзүүлэлт дэх жендэрийн агуулга</p> <p>4.ХАБ⁶, МХЕГ болон УЭ- ийн тогтолцоонд БХБ-ын салбарын ажиллагчдын ажлын нэхцэлтэй холбогдох жендэрийн шалтуур узыулэлтуудийг нэгтэх.</p> <p>5.Салбарын шилдэг байгууллага шалгаруулах шалтуур узыулэлтэд жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэй ажиллагчдад зохистой хөдөлмөрийн нэхцлийг бурдуулсан байдлыг оруулах.</p>
--	--	--	--

⁶ Хөдөлмөрийн аюулгүй байдал

2. Барилга, хот байгуулалтын салбарт ажиллагчдын зохистой хөдөлмөр эрхлэлтийг жндэрийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар дэмжих	Салбарын ажиллагчдад жндэрт нийцтэй ажиллагчдын зохистой хөдөлмөр эрхлэлтийг жндэрийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар дэмжих	1. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жндэрийн мэдрэмжтэй бодлого таллаар нэгдсэн ойлполт зөвшилцлийг бий болгож хамтын ажиллагааг эхлүүлэх	2. МХЕГ, БХБЯ, ХНХЯТ, УЭ, ЭМЯ ⁸ , салбарын ТББ-ын төлөөлөл хамтарсан баг байгуулж, барилын орчин нөхцөлд жндэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийн нэхцэл, хүний нөөцийн хөгжлийн жндэрийн мэдрэмжтэй бодлого таллаар нэгдсэн ойлполт зөвшилцлийг бий болгож хамтын ажиллагааг эхлүүлэх	<ul style="list-style-type: none"> Хамтарсан баг байгуулах тушаал хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жндэрийн мэдрэмжтэй бодлого таллаар нэгдсэн ойлполт зөвшилцлийг бий болгож хамтын ажиллагааг эхлүүлэх

6 ОГЛАВЛЕНИЕ

כתרון ג' ירושלים אוניברסיטאות ומוסדות מחקר

<p>НӨХЦЛИЙН ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ НАРИЙЧИЛСАН СУДАЛГААГ ХИЙХ.</p> <p>5. Салбарын эмэгтэй эрэгтэй ажиллагчдын мэргэжлээс шалтгаалах ёвчин, даатгал, тэтгэвэр, нийтийн хамгааллын нэхцэл байдалд ХНХЯ-тай хамтран унэлгээ хийж, салбар хоорондын зохицуулалтын хэргээг тодорхойлох.</p> <p>6. Барилгын салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөрт шилжүүлэхэд сургалтын тогтолцоо, нийгмийн хамгааллын арга хэмжээг жендерийн мэдрэмжтэй тодорхойлох хэлээцүүлэг, семинарыг туншлэгчдийн өргөн хүрээнд зохион байгуулах.</p> <p>• Барилгын салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан хөдөлмөрт шилжүүлэхэд сургалтын тогтолцоо, нийгмийн хамгааллын арга хэмжээг жендерийн мэдрэмжтэй тодорхойлох хэлээцүүлэг, семинарыг туншлэгчдийн өргөн хүрээнд зохион байгуулах.</p>	<p>асуудлаар олон улсын туршлагыг судлах.</p> <ul style="list-style-type: none"> Зохицой хөдөлмөр, жендерийн олон улсын чанартай сургалт семинаруудад хамрагдсан ажилтны тоо, хүйсээр
<p>2. Салбарын хүний нөөцийн нас, хүйсээр ангилсан мэдээллийн санг хөгжүүлж,</p> <p>1. Салбарын албан ба албан бус ажиллагчдын Мэргэжил, цалин хөлс, эрүүл мэндийн болон нийтийн даатгал, Мэргэжлийн болон хувь хүний сургалтад хамрагдант,</p> <p>• Салбарын албан ба албан бус ажиллагчдын талаарх нас, хуйс, иргэншилээр ангилсан</p>	<p>1. Салбарын мэдээллийн Нэгдсэн сан дахь нас, ангилсан хүйсээр мэдээллийн тоо</p> <ul style="list-style-type: none"> Салбарын албан ба албан бус ажиллагчдын талаарх нас, хуйс, иргэншилээр ангилсан <p>1. Салбарын албан ба албан бус ажиллагчдын хүйсээр ангилсан мэдээллийн багцыг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> Салбарын мэдээллийн Нэгдсэн сан дахь нас, хуйсээр ангилсан мэдээллийн тоо Нас, хуйсээр ангилсан мэдээллийн багцыг сайжруулах

			боловсруулан салбарын байгууллагуудад хүргүүлэх.
5.Ажилд авахад хүйс, насаар ялгаварлах, ажлын байран дахь бэлтгийн Дарамтаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сургалчилгаа, нэлтөөлийн ажлын гарган хэрэгжүүлэх.	• БХБЯ, түүний харьяа төрийн байгууллагуудад хүний байгууллагуудад хүний нөөцийн асуудлаар шийдвэр гаргах үйл явцыг илүү нээлттэй, оролцоотой болтох арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх.	1.Барилтын компаниудад төндэрт оруулах, оруулалтын дэмжгээт узүүлэх узүүлэлт цагинийн фондын хэмжээг тодорхойж тусгах.	• БХБЯ, түүний харьяа төрийн байгууллагуудад хүний нөөцийн асуудлаар шийдвэр гаргах үйл явцыг илүү нээлттэй, оролцоотой болтох чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо
4.Салбарын төр, хувийн хэвшлийн байгууллагуудад ад жендэрийн тэгш байдалд ээлтэй хүн төвт, нийгмийн хариуцлагатуд ирдлэгын загварыг түгээн дэлгэрүүлэх	2.Джилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрэд чиглэсэн арга хэмжээг төвлөвөх, хэрэгжүүлэхэд хамт олны оролцоо тулгуурлах зарчмыг БХБЯ-ны хөдөлмөрийн дотоод журамд тусган нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлэх.	• Хамт олны оролцоо, саналд тулгуурлан шийдвэрээн тоо, асуудлын нийгмийн тоо, байгууллагын тоо • Төндэрнийн шалтуур судалгаа талаар тогтолцоо эхчүүд, ХБИ, ганц бие эцгүүд, ХБИ, тэдний орон байрны Нэхцэл судалгаа талаар тогтолцоо хийж, хүний бодлого төлөвлөгөөд ашиглаж хэвших.	• Хамт олны оролцоо, саналд тулгуурлан шийдвэрээн тоо, асуудлын нийгмийн тоо, байгууллагын тоо • Төндэрнийн шалтуур судалгаа талаар тогтолцоо эхчүүд, ХБИ, ганц бие эцгүүд, ХБИ, тэдний орон байрны Нэхцэл судалгаа талаар тогтолцоо хийж, хүний бодлого төлөвлөгөөд ашиглаж хэвших.

		<p>материалын хүртээмж, чанарыг сайжруулахад төр, хувийн хэвшлийн хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх.</p> <p>8. Барилгын салбарт албан бус хөдөлмөр эрхэлж буй эмэгтэй эрэгтэйчүүдийн санал гомдлыг хулээн авах сувгийг БХБЯ-д бий болгох.</p>	<p>амрах, шаардлагатай тохиолдолд хоноглох ёреө бүхий ажлын орчны стандартыг нэвтрүүлэх.</p> <p>7. Ажигчдын хувьдэд зориулсан цэцэрлэгт байгуулах байгууллагын хэмжээг тодорхойлж, журам гарган нэвтрүүлэх.</p> <p>8. Зохицтой хөдөлмөрийн орчин нэхцөл бурдугулж, цэцэрлэгт байгуулах зэргээр ажил-ар гэрийн тэнцвэрийг хангасан байгууллага шалгаруулан, урамшуулан, хэвлэл мэдээллээр сурталчлах.</p>	<p>1. Барилгын материалын Уйлдвэрийн технологийн дамжуулалт, замаар эмэгтэйчүүд, ХБИ-г байгууллагын тоо, талаар оролцогсын хүйсээр програмчлах, замаар эмэгтэйчүүд, ХБИ ажиллах боломжийг нэмэгдүүлэх.</p> <p>2. Эмэгтэйчүүд, ХБИ, салбарт ажиллах груплэй байсан иргэдэд технологи зээмшилэх сургалтын тогтолцоог</p> <p>1. Барилгын материалын Уйлдвэрийн технологийн дамжуулалт, замаар эмэгтэйчүүд, ХБИ-г байгууллагын тоо, талаар оролцогсын хүйсээр програмчлах, замаар эмэгтэйчүүд, ХБИ ажиллах груплэй байсан иргэдэд технологи зээмшилэх сургалтын тогтолцоог</p>
5. Техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, ажлын орчин нөхцлийг сайжруулах замаар эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломжийг ажлын байрны тоог нэмэгдүүлэх		<p>1. БХБ-ын салбарт ХБИ¹⁰ эмэгтэйчүүд, ХБИ ажиллах боломжийг нэмэгдүүлэхүүц техник, технологийн талаар хийж, судалгаа бодлогын зөвлөмж гаргах.</p> <p>2. Барилгын материалын Уйлдвэрийн технологийн дамжулагыг програмчлах, автоматахуулсан ажиллуулсан эмэгтэйчүүд, ХБИ-г авч байгууллагын тоо, замаар эмэгтэйчүүд, ХБИ ажиллах груплэй байсан иргэдэд технологи зээмшилэх сургалтын тогтолцоог</p>	<ul style="list-style-type: none"> Судалгааны тайллангийн хэлэлцүүлэгт оролцогсын хүйсээр талаар хийж, замаар эмэгтэйчүүд, ХБИ ажиллах автоматахуулсан эмэгтэйчүүд, ХБИ-г авч байгууллагын тоо, замаар эмэгтэйчүүд, ХБИ ажиллах груплэй байсан иргэдэд технологи зээмшилэх сургалтын тогтолцоог 	<ul style="list-style-type: none"> Технологийн дамжулагагаа дограмчилж, замаар эмэгтэйчүүд, ХБИ-г авч ажиллуулсан байгууллагын тоо замаар эмэгтэйчүүд, ХБИ ажиллах боломжийг нэмэгдүүлэх. Нийт ажилтнуудад замаар эмэгтэйчүүд, ХБИ-ийн эзлэх хувь, салбараар, төр, хувийн хэвшлээр

¹⁰ Хөгжлийн берхшээлтэй иргэн

	<p>зуучлалын компани, ШӨХТГ, мэргэжлийн ТББ, орон нутгийн засаг захиргаа, СӨХ зэрэг салбарын үйл ажиллагаанд АЧСС багц Узуулэлтийг ашиглаж талаар зөвлөмж гаргаж хүргүүлэх.</p> <p>4. АЧСС-ыг хялбар ойлгомжтой хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх.</p>	<p>1. Хот суурин газрын тулагамдсан асуудлыг эрэгтэй хүмүүсийн, бүтгүүдийн оролцоотой судлан тодорхойлж хэлэлцүүлэх ажлыг жил бүр туншлэгчидтэй хамтран байгуулах.</p> <p>2. Хорооны газрын харилцааны булгүүдийн нийгмийн оролцож чадавхи, боломжийг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Хот суурин газрын тулагамдсан асуудлаар хийсэн хэлэлцүүлгээс барилга хот байгуулалтын салбарын ажиллагаатай холбогdon гарсан саналын тоо, жилээр барилгаар мэдээлэл чиглэлээр сургалтад хамрагдсан хороонь ажилтны тоо егех ажилтныг бий болгон чадвихжуулах. • СӨХ-ийн хүний нөөцийн бүтцийн орон судалгаа гаргаж, оршин оролцоог сайжруулах асуудлаар судалт хийх. 	<p>1. АЧСС, хэрэгжилтийг эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, бүтгүүдийн (ХБИ ГЭХ МЭТ)-ийн оролцоотой унэлгээ хийж, бодлогын зөвлөмж гарганс эргэх холбоог хантан</p> <ul style="list-style-type: none"> • Газрын харилцааны асуудлаар мэдээлэл чиглэлээр сургалтад хамрагдсан хороонь ажилтны тоо орон сууцны оршин сүүчдүүн сайжруулах чиглэлээр сургалтад хамрагдсан СӨХ-ийн ажилтны эзлэх хувь • СӨХ-ийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг сайтаараа танилцуулан оршин сууцдын <p>2. Барилга, байгуулалтын жендерийн мэдрэмжит байдлыг үнэлсэн хэрэглэгчдийн сэтгэл судалгааны тоо ханамжийн судалгаанд тусгах.</p> <p>3. Орон нутгийн бүтээн байгуулалт, хот тохижилтийн ажлын төсвийн зарцуулалтад хяналт оролцсон тоо, нас, хүйсээр, орон нутгаар СӨХ-ийн эрх зүйн тодорхой</p>
--	--	--	---	---

<p>хүмүүсийн, нийгмийн булгудийн гүйцэтгэх Уурэг, амьдралын хэрэгцээтэй нь уялдуулан жендерийн мэдрэмжтэй боловсруулж бие даасан нэвтрүүлэг, шторк гэх мэт төрөл бүрийн хэлбэрээр түгээх.</p>	<p>ухаалаг төлөвлөлтийн хотын чиглэлээр хэрэгжсэн төслийн ур дунд жендерийн үнэлгээ хийж түршлэгыг түгээн дэлгэрүүлэх. 8.Улаанбаатар хотын ерөнхий, хэсэгчилсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн бүх шатанд тавих хянгалтад иргэдийн хангах жендерийн мэдрэмжтэй төлөвлөө гарган хэрэгжүүлэх.</p>
<p>3.БХБ-ЫН салбарын жендерийн мэдрэмжтэй бодлогын цаашдын хөгжлийг туншлэл, хамтын ажиллагаагар дэмжих</p>	<p>1.Салбарын жендерийн бодлогыг хэрэгжүүлэх туншлэлийн зурагталааг гаргаж, салбарын жендерийн бодлогыг танилцуулах улзантг зохион байгуулах. 2. Нийтм, жендерийн асуудлаар салбар зохицуулалтын тоо хорондын зохицуулалтын тоо хамтын чиглэлийг тодорхойлж, ажиллагааг эхлүүлэх. 3.Ипотекийн зээл олголт, орон суучны түрээсийн нийтм, жендерийн үр нэлөөг судалж, туншлэлийн хамтын ажиллагааг танилцуулахад оролцочдын тоо, нас, хүйсээр нэеөөг судалж, ур дунг туншлэлийн үр нэлөөг хамтын чиглэлийг тодорхойлж, ажиллагааг эхлүүлэх.</p>
	<p>• Салбарын жендерийн бодлогыг танилцуулах улзантг зохицуулалтын тоо хамтын чиглэлийг тодорхойлж, ажиллагааг эхлүүлэх.</p> <p>1.Олон хэрэглэгчдийн ялгаатай хэрэглээг тооцсон, байгаль орчинд, эзлэй, үндэсний хэв шинжийг хадгалсан, орон нутгийн онцлогт нийцэн хот суурин, барилга, архитектурыг хөгжүүлэх судалгаа шинжилгээг төр, хувийн хөвшлийн туншлэлийн хүрээнд хөгжүүлэх.</p> <p>2.Барилга, байгуулалтын ажиллагааны байгаль орчин, нийгэм, жендерийн үр нэлөөг судалгаа шинжилгээний багийн гишүүдийн тоо, хүйсээр Салбарын хүний нэецийг бэлтгэх үйл хувцад жендерийн үнэлгээний жендерийн үнэлгээний</p> <p>• Олон хэрэглэгчдийн ялгаатай хэрэглээг тооцсон, байгаль орчинд, үндэсний хэв шинжийг хадгалсан, орон нутгийн онцлогт нийцэн хот суурин, барилга, архитектурыг хөгжүүлэх чиглэлээр хийсэн судалгаа шинжилгээний тоо Дээрх судалгаа шинжилгээний багийн гишүүдийн тоо, хүйсээр Салбарын ажилтан, суралцагчдад шинэ мэдээллийг хүргээд аргачлаал Унэлэх</p>

4. Салбарын хүний нөөцийг бэлтгэж буй төр, хувийн хэвшлийн боловоролын байгууллагуудын элсэгт, сургалтын үйл явц, төгсөлт болон төсөгчдийн ажил эрхлэгтийн байдалд бхбя, хнхя, БСШУСЯ ¹² -ны хамтарсан жэндэрийн үнэлгээ хийж зөвлөмж гарган хэрэгжүүлэх.	зөвлөмжийн хэрэгжүүлсэн хэмжээний тоо	мерөөр арга	боловсруулан нэвтрүүлэх.	3. Барилга, байгуулалтын чиглэлээр дэлхий дахинд гарч буй шинэ техник, барилтын материал, ХАБЭА-Н норматив, зохицстий хөдөлмөрийн шалтуур үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг салбарын суралцагчдад тогтмол хүргэх арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх.	ашиглаж буй хэрэгслийн тоо • Жэндэрийн мэдрэмжтэй барилга, хот байгуулалтын бодлого төлөвлөлтийг хөгжүүлэх асуудлаарх хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, нас, хүйсээр